



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №39

2019 оны 11 дүгээр сарын 25-29

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 1002 яаралтай дуудлагыг хүлээн авсан. Эдгээрийн 841(83.9%) хачигт халдвар, 123(12.3%) галзуугийн эрсдэлд өртсөн, 8(0.8) боом, 7(0.7%) тарваган тахал, 4(0.4%) хумхаа, 1(0.1%) ям, 5(0.5%) денги, 10(1.0%) бэтэг, 3(0.3%) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Энэ долоо хоногт зоонозын шалтгаант хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй байна.

1.1 Мэрэгч амьтны дуудлага

Энэ долоо хоногт нийслэлийн Нийслэлийн СХД-ийн Цагдаагийн I-р хэлтэс, “Эмээлт” АТШН товчооноос ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага) 2 удаагийн дуудлаганд үйлчилж, эрсдэлийг тодорхойлохоор лабораторийн шинжилгээ хийв. Сорьц материалыг шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна. Он гарсаар нийслэлийн 5 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ХУД) хэмжээнд нийт 107 удаагийн амьтны дуудлаганд үйлчилсэн байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуу өвчин:

Төв аймгийн Зуунмод сумын VI-р багийн малчин “Л”-ийн 1 үхэр 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр халдварт өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул сорьц авч Аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд мал, амьтны галзуу өвчин болох нь тогтоогдсон.

Авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ



- Тус сумын Засаг даргын захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон.
- Галзуугийн эсрэг вакцины эхний тунд 4 хүн хамрагдсан.
- Голомтод 29 өрхийн 129 (хонь, ямаа, үхэр) малыг вакцинуулсан.
- Төв аймгийн ЗӨСТ галзуу өвчнөөс сэргийлэх сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч ажилласан байна.

Эх сурвалж: Төв аймгийн ЗӨСТ

Олон улсад:

Эбола вируст халдвар:


2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 3298 тохиолдол бүртгэгдсэнээс 2197(67%) нь нас барсан байна. Нийт тохиолдлын 1859(56%) нь эмэгтэйчүүд, 931(28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзлэж байна.



Эх сурвалж: ДЭМБ

Шүлхий өвчин:

Өмнөд Африк улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 11 дүгээр сарын 20-нд Лимпопо тосгоны үхрийн аж ахуйд SAT-2 хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин бүртгэгдсэн. Нийт 2000 үхэр өртөмхий байснаас 1 үхэр өвчилсөн байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Шувууны томуу өвчин:

БНХАУ-ын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 11 дүгээр сарын 13-нд Юньлин мужийн шувууны аж ахуйд шувууны томуугийн H5N2 хэвшлийн вирусээр үүсгэгдсэн дэгдэлт бүртгэгдсэн. Нийт 100 шувуу өвчилж үхэн, 13220 шувууг устгасан байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Мал, амьтны галзуу өвчин:


Малайз улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 11 дүгээр сарын 26-нд Кучинг хотын Сарабак тосгонд мал, амьтны галзуу 1 нохой өвчилсөн. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.




Эх сурвалж: ДМАЭМБ

Ласса чичрэг өвчин:

Нигери улсын ӨХСТ-ийн 45 дугаар долоо хоногийн эргэн мэдээллээр 2019 оны 11 дүгээр сарын 03-10-ны хооронд Ласса чичрэг өвчний сэжигтэй 10 тохиолдол бүртгэгдсэнээс 2 нь нас барсан байна.



Тус улсад 2019 оны 01 дүгээр сарын 01-ээс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртлэх хугацаанд 23 мужаас Ласса чичрэг өвчний 4500 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 764 тохиолдол батлагдаж, 160(20.9%) нь нас барсан байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өвчилж үхсэн	Өвчилсөн	Устгасан
ДМАЭМБ	- Болгар улс - Шумен тосгон	2019.11.25	2019.11.20	Ойд		2 зэрлэг гахай	
ДМАЭМБ	- Латви улс - Салдус тосгон	2019.11.26	2019.11.21	Ойд			1 зэрлэг гахай
ДМАЭМБ	- Унгар улс - Хевэйс тосгон	2019.11.27	2019.11.19	Ойд	1 гахай		